

УБ.2002.-306х;

Өвгөнбүргэд.Ж.Хилчдийн эрх зүйн боловсролд.
УБ.2006.-154х;

Монгол улсын хил хамгаалалтын дүрэм. УБ.2007.-
160х;

Байлдааны Дүрэм 200.3ХЖШ.УБ.2004.-549х

Арвай.Ш. Монгол Улсын хил хамгаалалтанд

үзүүлэх хүчин зүйлийн нөлөөлөл цаашдын төлөв.
2001 УБ 270х

Жавхланцогт.В. Контрабанд. УБ.2007.-35х

ХЭЭРИЙН ОТРЯДЫН СУРГАЛТ БЭЛТГЭЛ FIELD TEAMS AND TRAINING



С.ЭНХСҮХ Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн 186-р
ангийн захирагч, хурандаа, докторант

ENKHSUKH S. Chief of Border Troops №186 Border Troops
Commander, Colonel

Товч агуулга: Энэхүү өгүүллээр хилийн отрядын сургалт бэлтгэлийг явуулах баримт бичиг, туршлага сургамж, түүнчлэн сургалт бэлтгэлийн өнөөгийн байдал, түүнд учирч буй хүндрэл бэрхшээл, цаашид улам боловсронгуй болгох санал, зөвлөмжийг дэвшүүлжээ.

Abstract: This article is about documents and lessons for the border teams training and experiences, as well as the current situation of the training and preparation and the difficulties faced by and recommendations for its further development.

Оршил:

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал тэр дундаа хилийн халдашгүй дархан байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй Хил хамгаалах байгууллагаас хилийн орон зайд явуулж байгаа үйл ажиллагааны үндсэн нэгж нь Хилийн отряд юм. Энэ нь Хилийн отрядын улс хил хамгаалах ажиллагаа нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны голлох чиглэлүүдийн нэг болохыг харуулж байгаа юм.

Хилийн отрядын улсын хил хамгаалах ажиллагааны үр дүн нь хилчдийн улсын хил хамгаалах албаны мэдлэг, чадвар, дадлагатай шууд холбоотой байдаг нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хилийн орон зайд хангах үйл ажиллагаанд Хилийн отрядын сургалт бэлтгэл чухал байр суурь эзлэж байна гэж үзэхэд хүргэж байна.

Хилийн отрядын бие бүрэлдэхүүний эрэлт хэрэгцээ, албаны шаардлагад нийцсэн сургалтыг явуулах

стандарт төлөвлөгөө, хөтөлбөр, хил хамгаалалтын онцлогт тохирсон сургалтын хэлбэрийг бий болгох зэрэг асуудал үгүйлэгдэж байгаа бөгөөд улсын хил хамгаалалтад гарч буй хэрэгцээ, шаардалга, хувьсал өөрчлөлттэй зохицсон сургалтын арга зүй, хэлбэрийг боловсронгуй болгох, бие бүрэлдэхүүнийг сургаж, дадлагажуулах асуудлыг цогцоор нь судлах шаардлага нэгэнт буй болсон байна.

Нэг. Сургалтын онол, арга зүй ба цэргийн сургалт бэлтгэл, ХХБ-аас сургалт, бэлтгэлийг зохион байгуулах талаар баримталж буй бодлого чиглэл, туршлага сургамж

Монгол Улс нь “Мэдлэгт суурилсан” хөгжлийн чиг хандлагыг сонгосон бөгөөд Хил хамгаалах байгууллага/цаашид ХХБ гэх/ ч уг зарчмын дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулж явуулах нь зайлшгүй юм. Энэ нь Монгол Улсын Үндэсний

аюулгүй байдлын үзэл баримтлал баримт бичгийн 1,2,4 дэх хэсэгт "...Аюулгүй байдалд хандах хандлага, түүнийг хангах үйл ажиллагаа нь мэдлэг, мэдээлэл, дүн шинжилгээнд суурилна..." гэж зааснаар баталгаажсан байна.

Монгол Улсын ҮАБ, хилийн халдашгүй дархан байдлыг хангах үйл ажиллагааг гардан зохион байгуулж байгаа ХХБ, тэр дундаа Хилийн отрядын /цаашид ХО гэх/ улсын хамгаалалтын үр дүн бие бүрэлдэхүүний албаны мэдлэг чадвартай шууд холбоотой бөгөөд түүнийг зөвхөн сургалтаар хангах боломжтой юм.

Сургалт бол нийгэм-түүхийн туршлагыг хойч үедээ дамжуулах үйл явц буюу тодорхой тогтолцоо бүхий мэдлэг, чадвар, дадал төлөвшүүлэх явц юм.

Сургалт-мэдлэг, чадвар, төлөвшлийн чанарын өөрчлөлт болох суралцхуйг хэрэгжүүлдэг зохион байгуулалтын тогтолцоо-суралцах, сурхуйн нэгдэл юм. Иймд сургалт нь мэдлэг, чадвар, дадлыг дамжуулах, үйл явц, түүнчлэн тасралтгүй боловсрол эзэмшихэд зайлшгүй шаардагдах танин мэдэх үйл ажиллагааны арга ч гэж үзэж болно.

Харин Цэргийн сургалт гэдэг нь цэргийн албан хаагчид эх орон, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах үүргээ биелүүлэхэд зайлшгүй шаардагдах мэдлэг, чадварыг эзэмшүүлэх, түүнийг үүссэн ямарч цагийн байдлын өрнөлтийн үед ашиглах дадлага олгох үйл явц юм.

Уг мэдлэг дадлага олгох үйл явцыг сургалтын технологи хэмээн боловсрол судлалын шинжлэх ухаанд тодорхойлон нэрлэдэг байна. Анх 1950-д оны үеэс сургалтад техникийн ололт амжилтыг нэвтрүүлж эхлэхтэй холбогдон технологи гэдэг үг сургалтад нэвтэрч эхлэсэн байна.

Өнөөдөр сургалтын технологи гэдэг ойлголтыг өргөн хүрээнд дэлхийн улс орнуудын сурган хүмүүжүүлэх ухааны эрдэмтэд ойлгож тодорхойлдог байна. Барууны зарим орнуудад сургалтанд техник хэрэгсэл ашиглах гэж тодорхойлдог байна. Мөн Японы эрдэмтэн Т.Сакамото "сургалтын технологи гэдэг боловсролыг буюу анги дахь сургалтыг системчлэх гэж нэрлэж болох сэтгэхгүйн системчлэх аргыг сурган хүмүүжүүлэх ухаанд нэвтрүүлэх явдал" [сургалтын технологийн шинэчлэл. Эмхтгэл.УБ.1999 он.94х 46] гэж тодорхойлсон байна. Харин нь Монголын эрдэмтэн судлаачид дараах байдлаар тус тусын судалгааны бүтээлүүддээ тодорхойлсон байна. Тухайлбал Ч.Лхагважав "сургалтын технологи гэдэг бол тэр өөрчлөлтийг буюу чанарын хувиргалтын үйл явцыг зохион байгуулах соёл буюу ур ухаан, арга зам" [сургалтын технологийн шинэчлэл. Эмхтгэл. УБ.1999 он.94х 24], Ш.Сарантуяа "...технологий нь хүмүүс өөрсдийнхөө хүсэл, хэрэгцээг хангахын тулд хамгийн шинэлэг зүйл, шинэ бүтээл болон шинжлэх ухааны нээлтийг ашиглах арга замууд." [сургалтын технологийн шинэчлэл. Эмхтгэл.УБ.1999 он.94х

46], Д.Ванчигсүрэн "сургалтын буюу хичээлийн технологи гэдэг нь сэтгэл зүй, сурган хүмүүжүүлэх болон удирдлагын ухааны зүй тогтолд тулгуурлан боловсруулагдсан аливаа үйлдлийг гүйцэтгэхэд хамгийн оновчтой эрэмбэ, дэс дарааллын хувилбар" [сургалтын технологийн шинэчлэл. Эмхтгэл.УБ.1999 он.94х 32] гэж тус тус тодорхойлсон байна.

Мөн Хилийн цэргийн дээд сургуулийн судлаачид албаны сургалтын технологийг "Хилийн албаны мэргэжлийн мэдлэг, дадлага, чадварыг олгох үйлийг зохион байгуулж, явуулах арга, хэлбэр, хэрэгслийг хамгийн оновчтой байдлаар ашиглах үйлдлийн эрэмбэ дарааллын зохистой хувилбар" [Хилчин сэтгүүл.2010.11.№11. д/х В.Жавхланцогт. Хилийн албаны сургалтын технологийг боловсронгуй болгох арга зам. Нийтлэл.] гэж тодорхойлсон байна.

Сургалтын технологийг судлаачид "...ХО-ын СБ-ын технологи нь сургах ба суралцах, ажиллагааны жигдрэлтийг хангах үйлдлийн нэгдэл байх бөгөөд дээрх тодорхойлолтод үндэслэн хичээлийн агуулга хоорондын уялдаа бүхий стандарт, арга зүйн оновчтой хувилбар бүхий дараах бүтэцтэй байхаар загварчилж болох юм. Үүнд:

1. Сургалтын зорилго;
2. Агуулга;
3. Хэлбэр;
4. Хэрэглэгдэхүүн;
5. Арга;
6. Үр дүн;
7. Үнэлгээ тус тус болно..." гэж загварчилсан нь оновчтой хувилбар гэж үзэхэд хүргэж байна.

Сургалтын технологийн дээрх агуулгаас үндэслэн сургалтыг үүсэн бий болж болзошгүй хилийн цагийн байдлын өрнөлтийн үед үүрэг гүйцэтгэх дадлага, чадвар эзэмшүүлэхэд чиглүүлэн зохион байгуулахад чухал хэсэг нь "Сургалтын хэлбэр" байна.

Цэргийн сургалтын хэлбэрүүд нь ерөнхий сургалтын хэлбэрүүдээс албаны онцлогт нийцсэн өвөрмөц онцлог бүхий ялгаатай дараах хэлбэрүүдийг ашигладаг. Үүнд:

1. лекц;
2. семинар;
3. бүлгийн дасгал;
4. тактикийн шуурхай дадлага;
5. тактик-жагсаалын хичээл;
6. тактикийн хичээл;
7. сурган зааварлах хичээл;
8. салбарын байлдааны буудлага;
9. хээрийн нэгдсэн хичээл;
10. штабын нэгдсэн ба хэсэгчлэсэн дадлага;
11. цэргийн тоглоом;

12. Тактикийн аргачилсан цогцолбор дасгал;
13. команд-штабын сургууль;
14. команд-штабын хээрийн сургууль;
15. тактикийн хээрийн сургууль;
16. байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургууль тус тус болно.

Дээрх сургалтын хэлбэрүүдээс хамгийн онцлог, ач холбогдолтой нь тактикийн хээрийн сургууль юм.

Тактикийн хээрийн сургууль нь үүссэн цагийн байдлын өрнөлтийн дагуу хилийн отрядын хүч хэрэгслийг нэгтгэн зохион байгуулах ба удирдаж явуулах талаар дарга, штаб, цэргийг дадлага практиктай болгож сургах хамгийн дээд хэлбэр гэж үздэг байна.

Хоёр. Хилийн отрядын сургалт бэлтгэлийг зохион байгуулан явуулж буй өнөөгийн байдал, үр дүнд нөлөөлж буй хүчин зүйлс

ХО-ын улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах нь "Хилийн алба", "Хилийн эрэл" болон "Тусгай үүрэг"-ийг гүйцэтгэх бэлтгэл сургалтын үр дүнгээс шууд шалтгаалж байгаа юм. ХО-ын сургалт бэлтгэл нь тухайн хариуцсан хилийн хэсгийн онцлог, хилийн цагийн байдал, байгаль, цаг уур зэрэг олон хүчин зүйлстэй харилцан хамааралтайгаар зохион байгууллагдаж байдаг хэдий ч зөвхөн хариуцсан хэсгийн хилийн халдашгүй дархан байдлыг хангах албаны хэрэгцээн дээр төвлөрөх шаардлагатай нь гол онцлог юм. Тиймээс ХО-ын сургалт, бэлтгэлийн үндсэн цөм нь тактикийн бэлтгэл байна гэж үзэж байна.

ХО, застав, харуулын болон цэргийн албан хаагч нэг бүрийн бэлтгэл сургалтын нийлбэр цогц нь тактикийн бэлтгэл байх бөгөөд энэ нь "Хилийн алба", "Хилийн цэргийн тактик", "Галын бэлтгэл", "Эрх зүй", "Жагсаал", "Биеийн тамир", "Тусгай үүргийн бэлтгэл", "Холбоо", "Инженер", "Эмнэлэг", "Ар тал"-ын хичээлүүд нь тухайн Хилийн отрядын улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах зорилго, үүрэгтэй нягт уялдан хэрэгждэг байх шаардлагатай юм.

ХХБ-ын бие бүрэлдэхүүний сургалт нь улсын хил хамгаалалтад шаардлагатай бүхэнд сургах зарчимд тулгуурлан явагдах бөгөөд сургалтад хамрагдаж байгаа бүрэлдэхүүнээс хамаарч сургалтыг дараах байдлаар ялгамжтай тогтоодог. Үүнд:

1. Албаны болон цагийн байдлын өрнөлтийн үед үүрэг гүйцэтгэх бэлтгэл олгох сургалт;
2. Штабын бэлтгэл;
3. ХХЕГ-ын бие бүрэлдэхүүний бэлтгэл сургалт;
4. ХО-ын бие бүрэлдэхүүний бэлтгэл сургалт тус тус болно.

Сургалт зохион байгуулах зааврын дагуу ХО-

ын бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг тухайн хичээлийн жилийг календарийн хугацаагаар тооцон ХО-ын даргын 02 тоот тушаал гаргах замаар зохион байгуулж явуулдаг. ХХБ-ын бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг 1-4 дүгээр сар хүртэл 1 дүгээр үе, 7-10 сар хүртэлх хугацаанд тус тус 2 үе болгон зохион байгуулдаг нь ХХБ-ын үйл ажиллагаа, улсын хил хамгаалах эрх ашигт нийцүүлсэн онцлог болж байгаа юм.

ХО-ын сургалт бэлтгэлийг зохион байгуулахад дараах зөрчил дутагдал оршиж байна. Үүнд:

- ХХБ-ын хэмжээнд нэгдсэн хөтөлбөр, төлөвлөлт бүхий сургалтын сэдэвтэй байдаг нь байгаль цаг агаар, газар зүй, хилийн цагийн байдлын хувьд янз бүр, харилцан адилгүй ачаалал бүхий хилийн хэсгүүдэд байрлаж буй ХО-ын эрэлт хэрэгцээг хангахгүй байна;
- Сургалтын хэрэглэгдэхүүн ном сурах бичиг, гарын авлага дутагдалтай байдаг;
- Сургалтыг ХО-ын албаны дарга нар, зарим офицеруудаар заалгадаг нь юу заахаа мэддэггүй, мэдээжийн зүйлийг ярьж, цаг үрсэн байдлаар залхаадаг;
- Сургалтын агуулгад ХО-ын алба хаагчдын эрэлт хэрэгцээ төдийлэн тусгагдаагүй байдаг;
- Албанд тулгарч байгаа бэрхшээлт асуудлыг шийдвэрлэх гарц, зөвлөмж, аргачлалын талаар сургалтад тусгах асуудал ихээхэн дутагдалтай байдаг зэрэг болно.

Гурав. Хилийн отрядын сургалт оновчтой зохион байгуулах арга зам, сургалтын хэлбэрийг боловсронгуй болгох санал, зөвлөмж боловсруулах.

ХО-ын сургалт бэлтгэл нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах чиг үүрэг, ХХБ-ын хэтийн хөгжил, улсын хил хамгаалалтын эрэлт хэрэгцээнд нийцсэн, бие бүрэлдэхүүнийг албаны үйл ажиллагааг зохион байгуулахад хэрэгтэй бүхэнд сургах зорилготойгоор явагдах зарчмын дагуу "...ХО-ын сургалт бэлтгэл нь тухайн хилийн хэсгийн албаны хэрэгцээнд төвлөрсөн байх..." гэсэн агуулгаар боловсруулах нь зүйтэй юм.

Мөн сургалт бэлтгэлийг ХО-ын сургалтын тасгаас тодорхой агуулга, багтаамж үгүй хичээлийн нэрсийн жагсаалтыг тушаалаар батлуулан сургалтыг зохион байгуулж, байгаа нь сургалт явуулах цаг хугацаатай зохицохгүй, хичээлийн агуулгын уялдаа холбоо бүрдэхгүйд хүрч улмаар сургалт бэлтгэлээр дэвшүүлсэн зорилгыг хангахад сөргөөр нөлөөлж буй нэг хүчин зүйл болж байгаа юм. Тиймээс ХО-ын сургалт бэлтгэлийн төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсрол судлалын ухааны зарчим, нийтлэг хандлагын дагуу, Улсын хил хамгаалах алба, ХО-

ын хэрэгцээ, боломжид үндэслэн дараах байдлаар эрэмбэлэн тогтоож, боловсруулах нь зүйтэй юм. Үүнд:

- Сургалтын төлөвлөгөө;
- Хичээлийн хөтөлбөр;
- Ээлжит хичээлийн цаг, сэдвийн төлөвлөлт тус тус болно.

ХО-ын сургалт бэлтгэлийг зохион байгуулах цаг хугацааны үе шатанд дараалсан байдлаар хилийн отрядын нийт бие бүрэлдэхүүний өмнөх мэдлэг, чадвар, дадлагад суурилан хөгжүүлэх хэлбэрээр сургалт бэлтгэлийг зохион байгуулах боломжтой гэж үзэж байна. өөрөөр хэлбэл Хилийн отрядын сургалтын үечлэл бүрт сургалтын нэг сэдвийг дэвшүүлэн тавьж, 1 дүгээр бүлэгт дурьдсан сургалтын хэлбэрүүдийг шат дараалан хэрэгжүүлэх замаар сургалтыг зохион байгуулж, эцэст нь нийт бүрэлдэхүүнийг хамарсан “Тактикийн хээрийн сургууль явуулж дуусгана. Жишээлбэл: Тухайн хилийн отрядын сургалтын нэгж хугацаанд “Хилийн эрэл, түүнийг зохион байгуулж явуулах дадлага, чадварыг дээшүүлэх” гэсэн сэдвийг дэвшүүлэн тавьж болно. энэ тохиолдолд бие бүрэлдэхүүний сургалтын хүрээнд офицер, ахлагч, хугацаат ба гэрээт цэргийн алба хаагчид, Хил хамгаалалтад туслах хүчний гишүүдэд гүйцэтгэх үүрэгтэй нь холбоотой агуулгаар дараах байдлаар зөвхөн хилийн эрэлтэй холбоотой хичээл сургалтыг зохион байгуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Хилийн албаны тактикийн хээрийн сургууль нь ХО-ын дарга, штаб, бие бүрэлдэхүүний алба-байлдааны ажиллагааг явуулах нэг ерөнхий сэдэв, бодомжоор газар орон, улирал, цаг уур, хоногийн шилжилтийн төрөл бүрийн нөхцөлд их талбайд, манай нутаг цөмрөн халдсан зэвсэгт халдлагыг няцаах, алан хядах, зохион байгуулалттай гэмт хэргийн бүлгийг устгах, хил зөрчигчийг эрж баривчлах, хилийн эрэл хийх, операц явуулах мөн ерөнхий цэргийн байлдааны ажиллагааг явуулах, гамшиг онцгой нөхцөл байдал үүссэн үед ажиллах зэрэг асуудлаар дадлагжуулахад хилийн албаны хээрийн сургуулийг чиглүүлнэ.

Хилийн албаны тактикийн хээрийн сургуулийн явцад нийт бүрэлдэхүүн нэгэн бодлогоор тасралтгүй өрнөн хөгжих цагийн байдалд янз бүрийн газар орон дээр, ямар ч нөхцөлд үүргээ практик дээр завсарлагагүй явуулан сурган дадлагажуулдагт уг сургалтын мөн чанар оршино.

хилийн албаны онцлогт тохируулан нэг хилийн отрядын хүч хэрэгсэл, бүрэлдэхүүн оролцосон Хилийн албаны тактикийн хээрийн сургуулийг 1,5-2,5 хоногт багтаан зохион байгуулж болох юм гэсэн саналтай байна.

Хилийн отрядын хэмжээний тактикийн хээрийн сургуулийн бэлтгэл нь дараах ажлыг багц байдлаар

хангаснаар хэрэгжинэ. Үүнд:

- анхны өгөгдөхүүнийг тодорхойлох /сургуулийн сэдэв, зорилго, сургуулийн шатууд, боловсруулах асуудлууд, сургуульд оролцох талуудын бүрэлдэхүүн, сургууль явуулах район, сургуулийн үргэлжлэх хугацаа, моторесурс, сум галт хэрэгслийн зарцуулах норм гэх мэт/;
- ТХС-ийг бэлтгэж явуулахад шаардагдах баримт бичгүүдийг боловсруулах;
- сургууль хийх районыг бэлтгэх;
- удирдлагын офицеруудыг бэлтгэх;
- сургуульд оролцох захирагч, штаб, анги, салбаруудыг бэлтгэх зэрэг арга хэмжээнүүд багтдаг.

Хилийн албаны тактикийн хээрийн сургуулийг бэлтгэх ажлын хүрээнд боловсруулж байгаа баримт бичгүүд нь сургалтыг нэгдсэн бодлого, төлөвлөлттэй, урьдчилан бэлтгэгдэж, зохион байгуулагдсан байх шаардлагыг хангасан байх зарчмаар дараах үндсэн баримт бичгүүдийг боловсруулна. Үүнд:

- Хилийн албаны тактикийн хээрийн сургуульд бэлтгэх клендарчилсан төлөвлөгөө;
- Сургуулийн зохион байгуулалтын заавар;
- Хилийн албаны тактикийн хээрийн сургуулийн бодлого-төлөвлөгөө;
- Тактикийн хээрийн сургуулийн аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө;
- Дундын хянагч нарын нэгдсэн ба хэсэгчилсэн төлөвлөгөө
- Тактикийн даалгавар, захирамжууд
- Газар орны туршуулын төлөвлөгөө
- Хилийн албаны тактикийн хээрийн сургуулийг удирдах төлөвлөгөө
- Цагийн байдлыг хөгжүүлэх төлөвлөгөө
- Байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуульд
 - Байн цагийн бүдүүвч
 - Цель заах журам
 - Сум галт хэрэгслийн тооцоо
 - Гал удирдах, холбоо зохион байгуулах журам зэрэг болно.

Хилийн албаны тактикийн хээрийн сургуулийг бэлтгэх дээрх баримт бичгүүдээс Сургуулийн бодлого-төлөвлөгөө нь хамгийн гол үндсэн баримт бичиг мөн. Сургууль явуулах бодлого-төлөвлөгөөг цэргийн байр зүй зураг дээр боловсруулж дараах асуудлуудыг тусгасан байна. Үүнд:

- сургуулийн сэдэв, зорилго, явуулах хугацаа;
- сургуульд оролцуулах бүрэлдэхүүн;
- моторесурс, сум галт хэрэгсэл болон дууриалган үзүүлэх хэрэгслийн зарцуулалтын норм;

- сургуулийн шат, тэдгээрийн үргэлжлэх хугацаа, сургуулийн асуудлууд, удирдагчаас авч явуулах арга хэмжээнүүд;
- тактикийн бодлого /сургууль эхлэх үеийн хоёр талын дээд шатны анги, салбарын байрлал, бүлэглэл, гүйцэтгэх үүрэг болон сургуулийн удирдагчийн /захирагчийн/ шийдвэр, сургагдаж байгаа анги, салбар болон зэргэлдээх хилийн отрядын үүрэг /тэдний гаргаж болзошгүй шийдвэрийг заахгүйгээр/;
- хоёр талын байлдааны ажиллагааг тоглож болзошгүй район /зааг/-ууд, байлдааны буудлага хийх хэсэг /хэрэв байлдааны буудлага хийвэл/;
- сургуулийн үндсэн үзүүлэлтүүд /сургалтад ашиглагдаж байгаа газар орны хэсгийн үүргийн гүн, өргөн, удирдлагын бүлгээс байлдааны ажиллагааг зохион байгуулахад ноогдох цаг, маршийн хурд, хүч хэрэгслийн боломж, хилийн манааны нягтрал/ тус тус болно.

Хилийн албаны тактикийн хээрийн сургуулийг дээр дурьдсанчлан Хилийн эрлийн сэдвээр зохион байгуулж байгаа тохиолдолд хилийн зөрчил гарсан мэдээллийг аваад Хилийн отрядын томилгоот бүлгүүдэд команд өгсний дараа хил зөрчигчийн байдалд үнэлгээ хийж хил зөрчигчийн байж болзошгүй районыг тодорхойлж, Хилийн эрлийн үед хэрэгжүүлэх цогцолбор арга хэмжээг Хил Хамгаалалтын 1 дүгээр ангийн дүрмийн “Отрядын хэсэгт хилийн эрэл явуулах” гэсэн 8 дугаар бүлгийн 134 дүгээр зүйлд заасны дагуу зохион байгуулна.

Хилийн албаны тактикийн хээрийн сургуулийн тактик ажиллагааны тоглолт дууссаны дараа салбаруудыг байнгын байрлалдаа буцаан зэвсэг техник, эд зүйлс, бие бүрэлдэхүүнийг байрлуулсны дараа сургалтын үндсэн хэсэг дууссанд тооцно.

Хилийн албаны тактикийн хээрийн сургуулийг зохион байгуулж явуулснаар хүрсэн ололт амжилт, алдаа дутагдалд үнэлгээ хийж ажлыг үргэжлүүлэн тусгай төлөвлөгөөгөөр зохион байгуулах ажлыг ХО-ын мэргэжлийн албадаас томилогдсон баг тусгайлан явуулж бие бүрэлдэхүүнд дүнг хүргэн холбогдох материалыг хадгалалтад авснаар уг Хилийн албаны

тактикийн хээрийн сургууль бүрэн дууссанд тооцох боломжтой юм үзэж байна.

Дүгнэлт, санал

ХО-ын улсын хил хамгаалах ажиллагааны үр дүн хилчдийн улсын хил хамгаалах албаны мэдлэг, чадвар, дадлагатай шууд холбоотой байдаг нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хилийн орон зайд хангах үйл ажиллагаанд хилийн отрядын сургалт бэлтгэл чухал байр суурь эзэлж байгааг илэрхийлж байгаа юм. Тиймээс сургалт бэлтгэлийн үйл ажиллагааг сайжруулж үр дүнг дээшлүүлэх нь үүссэн ямар ч цагийн байдлын өрнөлтийн үед хилийн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, хууль зүйн хүрээнд шийдвэрлэх замаар улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах нөхцлийг бүрдүүлнэ гэж үзэж байна.

ХО-ын сургалт бэлтгэл нь тухайн хилийн хэсгийн онцлог улсын хил хамгаалалтын эрэлт хэрэгцээнд тулгуурласан агуулгатай, цэргийн сургалтын онол арга зүйн хүрээнд зохион байгуулагдах онцлогтой байна.

Сургалтыг зохион байгуулах ХО-ын даргын тушаалаар тодорхойлогдсон хичээлийг сургалтын онол, арга зүйн мэдлэг багатай, урьдчилан бэлтгэгдээгүй, алба, нэгжийн офицер, алба хаагчдаар заалгаж байгаа нь үр дүн бага болгоход нөлөөлж байна.

ХО-ын сургалт бэлтгэлийн хүрээнд зохион байгуулагдаж байгаа хичээлүүд нь нэгдсэн зорилгод чиглэгдээгүй салангад агуулгатай байгаа нь албаны эрэлт хэрэгцээг бүрэн хангахгүй байна.

ХХБ-ын хэмжээнд ХО-ын болон цэргийн сургалтыг зохион байгуулж ирсэн туршлага арвин байгаа бөгөөд цаашид албаны эрэлт хэрэгцээнд тулгуурласан байдлаар боловсронгуй болгох боломжтой.

ХО-ын сургалт бэлтгэлийг сургалтын үе шат бүрт улсын хил хамгаалах албаны үйл ажиллагааны нэг чиглэлийг сургалтын сэдэв болгон дэвшүүлэн тавьж, бүх шатны сургалтыг чиглүүлэн явуулж төгсгөлд нь “Хилийн албаны тактикийн хээрийн сургуулийг зохион байгуулж” явуулж хэвших нь зүйтэй юм.